



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/154

Улаанбаатар хот

Улсын комисс томилон ажиллуулах
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 6.1.13, Эрчим хүчний сайдын 2019 оны 125 дугаар тушаалаар баталсан “Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам”-ын 3.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулсан санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл”-ийн хүрээнд “Даралт өргөх насос станц №2-ын хүчин чадлыг нэмэгдүүлэх” барилга угсралтын ажил дууссантай холбогдуулан уг барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулсугай.

Комиссын дарга:

Л.Мөнхцог

-Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Дулааны хэлтсийн ахлах шинжээч

Гишүүд:

Б.Мөнхчулуун

-Эрчим хүчний яамны Салбарын хяналтын газрын шинжээч

Б.Энхтөр

-Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Дулааны хэлтсийн мэргэжилтэн

Т.Мөнхбаяр

-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

М.Батсайхан

-Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн мэргэжилтэн

Я.Чулуун

-Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын архивын эрхлэгч

Ш.Мөнхжаргал

-"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн Ерөнхий инженер

Ч.Лхагважаргал

-"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн Дамжуулах сүлжээний цахилгаан тоноглолын албаны дарга

17060000371

Ч.Цэцэг	- "Ар төгөл" ХХК-ийн Дулааны инженер /Зураг төслийн байгууллага/
А.Цогтжав	- "Эрчим төсөл" ХХК-ийн Зөвлөх инженер /Зураг төслийн байгууллага/
Ц.Төгөлдөр	- "Майнтек технологи" ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Зөвлөх байгууллага/
Д.Ариунболд	- "Эй Жи Зэт" ХХК-ийн захирал /Гүйцэтгэгч байгууллага/

Нарийн бичгийн дарга:

С.Мөнхбаяр	"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн Европын сэргээн босголт хөгжлийн банкны төслийн нэгжийн ахлагч
------------	--

2. Эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллахыг Улсын комисс /Л.Мөнхцог/-т даалгасугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН